

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
	2.1. Оршил	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
	2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
	2.11. Шилэн дансны мэдээлэл	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал.....	10
	3.1 Балансын данстай холбоотой асуудал.....	10
	3.2 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
	4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



「АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
С.ЭНХБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/297
танай _____-ны № _____-т

「 Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архивын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Архивын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Архивын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус төсвийн байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Архивын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын дарга С.Энхбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архивын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архивын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 22-ноос 2019 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн аудитор А.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Архивын ерөнхий газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Архивын ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Архивын ерөнхий газар нь “Монгол төрийн ой санамж, түүх, соёлын үнэт баримтыг хадгалан хамгаалж, өнгөрснийг одоотой, одоог ирээдүйтэй холбон, албан хэрэг хөтлөлтийн тогтолцоог олон улсын стандартад хүргэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Архивын тухай хуулиар Архивын ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улс дахь үндэсний архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтын талаар арга зүйн нэгдсэн зарчим, хэм хэмжээ тогтоож мөрдүүлэх;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;
- Төрийн архивын ажлын журмыг баталж, мөрдүүлэх;

- Төрийн бүх шатны байгууллагын архивын баримтын хадгалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, хамгаалалтын үйл ажиллагааг зохицуулж мэргэжлийн туслалцаа үзүүлэх;
- Төрийн архивыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тэдгээрийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх;
- Архивын сан хөмрөгийн баримтын улсын бүртгэл хөтөлж, тэдгээрийн агуулга, бүрэлдэхүүн, байршлын талаар мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;
- Төрийн архивын үйл ажиллагаа, материал хангамж, боловсон хүчний талаар нэгдмэл бодлого явуулах;
- Архивын асуудлаар гадаад орнууд, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Гадаад орнуудад байгаа Монгол Улсын түүх, соёлд холбогдох архивын баримтыг олж илрүүлэх, хуулбарлах, худалдан авах ажлыг зохион байгуулах.

Архивын ерөнхий газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Архивын ерөнхий газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Архивын тухай хууль
- Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Эрх зүйн орчны талаар томоохон өөрчлөлт гараагүй

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Архивын ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Архивын ерөнхий газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Архивын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд (Бага) гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй) гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Архивын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурийг үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон авсан бөгөөд гүйцэтгэлийн шатанд их хэмжээний өөрчлөлт гараагүй тул суурийг хэвээр сонгох нь зохимжтой гэж үзэв.

Архивын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,322,703.1 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 86,454.06 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

				/мянган төгрөг/	
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар	
1	Зөвлөмж өгсөн	2	271,571.2		
	Дүн	2	271,571.2		

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 6656 ам.метр талбай бүхий 146.964.5 мянган төгрөгийн газрыг үнэлж, данс бүртгэлд тусгасан байна. Энэ газар дээр ажиллагсад зориулсан үйлчилгээтэй орон сууцны барилга барьж байна. Цаашид энэ газрын эзэмшил, ашиглалт Архивын ерөнхий газарт хамааралтай байх эсэхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх нь зүйтэй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Архивын ерөнхий газарт 2018 онд 3,320,044.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 3,196,069.5 мянган төгрөг зарцуулж, 123,975.4 мянган төгрөг хэмнэсэн байна.

Зардал хэмнэсэн гол шалтгаан нь шуудан холбооны зардлыг 5,895.5 мянган төрөг, бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 3,619.2 мянган төгрөг, дотоод томилолтын зардлыг 10,612.7 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 11,000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Гэвч тээвэр шатахууны зардлыг 8,456.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь ажлын байр хотын төвөөс 20 гаруй км зайтай байдагтай холбоотой байна.

Архивын ерөнхий газар 2018 онд туслах үйл ажиллагаанаас 220,080.0 мянган төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 368,038.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 167.3 хувь буюу 142,958.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлого давуулан биелүүлсэн нь 2019 оны онд архивын албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг болохтой холбоотой сургалтын орлого, албан бланк хэвлэлтийн орлого нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Архивын ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Архивын Ерөнхий газар нь дараах 3 үзүүлэлтийг сар бүр оруулж шилэн дансанд байршуулсан байна. Үүнд:

1. Төсвийн байгууллагын төсвийн гүйцэтгэл хэмнэлт, хэтрэлт
2. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт
3. Цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба гүйцэтгэл нь 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Архивын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Архивын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн тайлан санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Архивын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Архивын ерөнхий газар 2018 оны жилийн эцсээр өглөг, авлагын үлдэгдэлтэй 2 байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулсан боловч гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны төлбөрийн тооцоог бүрэн барагдуулж жилийн эцсийн байдлаар үлдэгдэлгүй гарсныг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь “Үнэн зөв байх батламж” мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Тайлант хугацаанд тооцоо үүссэн харилцагч тус бүртэй тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлыг хүлээн зөвшөөрсөн

3.2 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Батлагдсан төсвийн ангилал зориулалтыг зөрчиж дотоод томилолтын зардлаас 25,456.4 мянган төгрөгийн шатахуун бэлтгэсэн

Энэ нь “Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.15.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан эсэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төлөвлөгөө боловсруулахдаа шатахууны зардлыг өөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бодитой төлөвлөх. Шатахууны үлдэгдлийг дараа жилийн төсвөөс хасаж төлөвлөх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлыг хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	292,419,956.49	426,909,783.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,156,946.00	21,520.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	8,156,946.00	21,520.00
31110	Төгрөг	8,156,946.00	21,520.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		
33	АВЛАГА	980,000.00	8,050,224.00
335	Бусад авлага	980,000.00	8,050,224.00
3351	Байгууллагаас авах авлага		8,050,224.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	980,000.00	
34	УРЬДЧИЛГАА	00.00	24,637,719.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	24,637,719.00
35	БАРАА МАТЕРИАЛ	283,283,010.49	394,200,320.86
354	Хангамжийн материал	283,283,010.49	394,200,320.86
35410	Бичиг хэргийн материал	72,447,183.30	71,846,308.30
35420	Аж ахуйн материал	191,825,827.19	267,894,012.56
35440	Түлш, шатах тослох материал	19,010,000.00	54,460,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	16,757,075,375.43	16,283,756,357.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,757,075,375.43	16,283,756,357.40
392	Биет хөрөнгө	16,629,458,787.49	15,752,321,156.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	13,554,248,819.00	12,671,024,219.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-994,410,176.13	-633,551,211.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	234,057,700.00	305,057,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-224,936,172.43	-212,852,839.15
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,352,947,455.00	4,454,023,455.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-805,827,330.23	-1,265,209,512.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	865,811,891.00	870,408,675.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-364,326,000.72	-450,382,931.67
39217	Ном	11,892,602.00	13,803,602.00
393	Биет бус хөрөнгө	127,616,587.94	531,435,200.90
39301	Програм хангамж	199,740,292.00	204,590,292.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-72,123,704.06	-100,310,471.10
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	427,155,380.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,049,495,331.92	16,710,666,141.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	960,000.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	960,000.00	00.00
413	Өглөг	960,000.00	00.00
4136	Бусад өглөг	960,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	960,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,048,535,331.92	16,710,666,141.26
51	Засгийн газрын хувь оролцоо	17,048,535,331.92	16,710,666,141.26
511	Засгийн газрын оруулсан капитал	2,076,072,741.26	2,503,228,121.26
51101	Өмч: - төрийн	2,076,072,741.26	2,503,228,121.26
512	Хуримтлагдсан үр дүн	13,010,229,432.02	12,245,204,861.36
51210	Өмнөх үеийн үр дүн	13,010,229,432.02	13,010,229,432.02
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-765,024,570.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,962,233,158.64	1,962,233,158.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,049,495,331.92	16,710,666,141.26

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,352,198,738.00	3,557,678,534.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	252,232,518.00	261,264,195.00
120	Нийтлэг татварын бус орлого	252,232,518.00	261,264,195.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	252,232,518.00	261,264,195.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	234,872,379.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		256,548,795.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,360,139.00	4,715,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,099,966,220.00	3,296,414,339.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,073,612,974.00	3,188,964,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,073,612,974.00	3,099,964,900.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	00.00	89,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,353,246.00	107,449,439.00
131106	Төсвийн урамшуулал	26,353,246.00	107,449,439.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,800,230,455.83	4,025,841,190.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,603,075,616.84	3,868,000,838.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,603,075,616.84	3,868,000,838.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,952,804,775.22	2,112,589,877.86
210101	Үндсэн цалин	779,929,400.00	813,809,076.00
210102	Нэмэгдэл	275,861,500.00	337,160,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,710,200.00	164,710,200.00
210104	Урамшуулал	138,841,079.00	148,421,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	593,462,596.22	648,488,801.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	238,692,200.00	247,231,932.85
210201	Тэтгэврийн даатгал	153,209,481.93	182,618,098.85
210202	Тэтгэмжийн даатгал	24,661,622.09	16,088,283.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,412,656.98	14,261,655.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,150,213.00	3,151,786.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,258,226.00	31,112,110.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,374,040.18	246,114,777.34
210301	Гэрэл, цахилгаан	49,511,003.00	58,119,532.00
210302	Түлш, халаалт	141,000,000.00	155,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	24,863,037.18	32,995,245.34
2104	Хангамж, бараа материалын зардал	139,317,744.21	170,296,317.63
210401	Бичиг хэрэг	60,189,327.40	82,334,515.63
210402	Тээвэр, шатахуун	27,315,000.00	28,838,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,510,230.61	21,317,969.49
210404	Ном, хэвлэл	6,086,839.00	321,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,960,000.00	8,421,580.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,256,347.20	29,062,192.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,358,287.50	75,227,411.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,850,000.00
210604	Урсгал засвар	22,358,287.50	70,377,411.00
2107	Томилолт, зочны зардал	16,225,228.00	44,479,945.00
210701	Гадаад албан томилолт	00.00	10,256,710.00
210702	Дотоод албан томилолт	16,225,228.00	25,784,590.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	8,438,645.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	111,560,828.00	92,551,145.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,695,595.00	40,015,090.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	5,940,000.00

Архивын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	1,995,340.00	3,446,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	321,400.00	796,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	10,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,088,000.00	12,166,090.00
210807	Газрын төлбөр	2,879,720.00	4,968,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	28,580,773.00	25,208,765.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	906,742,513.73	879,509,431.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,519,100.00	6,052,610.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,657,097.90	68,410,554.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	817,566,315.83	805,046,267.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	197,154,838.99	157,840,351.95
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	3,045,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	3,045,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,382,674.00	55,959,130.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	42,808,130.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,382,674.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,000,000.00	13,151,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	118,772,164.99	98,836,221.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,772,164.99	98,836,221.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-448,031,717.83	-468,162,656.07
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,683,604.86	296,861,914.59
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,683,604.86	296,861,914.59
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,683,604.86	-296,861,914.59
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-453,715,322.69	-765,024,570.66

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,336,037,709.00	3,552,003,134.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	236,072,489.00	255,588,795.00
120	Нийтлэг татварын бус орлого	236,072,489.00	255,588,795.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	236,072,489.00	255,588,795.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	236,072,489.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	255,588,795.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,099,966,220.00	3,296,414,339.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,073,612,974.00	3,188,964,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,073,612,974.00	3,099,964,900.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	89,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,353,246.00	107,449,439.00
131106	Төсвийн урамшуулал	26,353,246.00	107,449,439.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,629,107,371.00	3,358,704,776.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,629,108,371.00	3,358,704,776.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,883,178,532.01	3,201,015,424.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,952,804,775.22	2,102,880,734.71
210101	Үндсэн цалин	779,929,400.00	889,662,735.00
210102	Нэмэгдэл	275,861,500.00	337,160,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,710,200.00	164,710,200.00
210104	Урамшуулал	138,841,079.00	148,421,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	593,462,596.22	562,925,999.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	238,494,500.00	243,612,400.00
210201	Тэтгэврийн даатгал	139,121,900.00	164,626,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,874,500.00	19,746,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,774,100.00	16,464,616.51
210204	Ажилгүйдлийн даатгал	3,974,900.00	3,949,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,749,100.00	38,825,683.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,374,040.18	246,114,777.34
210301	Гэрэл, цахилгаан	49,511,003.00	58,119,532.00
210302	Түлш, халаалт	141,000,000.00	155,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	24,863,037.18	32,995,245.34
2104	Хангамж, бараа материалын зардал	134,975,403.61	169,137,716.00
210401	Бичиг хэрэг	37,262,817.00	37,975,709.00
210402	Тээвэр, шатахуун	38,681,200.00	44,110,460.51
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,588,230.61	22,720,469.49
210404	Ном, хэвлэл	4,658,267.00	8,849,470.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,397,100.00	12,496,940.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,387,789.00	42,984,667.00
2105	Нормативт зардал	3,101,700.00	6,268,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,101,700.00	6,268,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,551,745.00	69,638,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,661,455.00	9,797,509.00
210604	Урсгал засвар	53,890,290.00	59,841,291.00
2107	Томилолт, зочны зардал	26,150,228.00	78,351,300.00
210701	Гадаад албан томилолт	-	10,556,710.00
210702	Дотоод албан томилолт	16,225,228.00	42,784,590.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,925,000.00	25,010,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	166,884,359.00	216,691,490.00

Архивын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,963,888.00	74,007,290.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,940,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,995,340.00	3,446,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	321,400.00	796,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,556,100.00	54,273,000.00
210807	Газрын төлбөр	2,879,720.00	4,968,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,110.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	55,165,801.00	73,260,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,841,781.00	68,320,206.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,859,000.00	6,207,610.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	74,982,781.00	62,112,596.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	745,929,838.99	157,689,351.95
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	3,045,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	3,045,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,382,674.00	55,808,130.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	42,808,130.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,382,674.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,000,000.00	13,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	667,547,164.99	98,836,221.95
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	548,775,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,772,164.99	98,836,221.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(293,069,662.00)</u>	<u>193,298,358.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	247,564,192.00	201,433,784.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	247,564,192.00	201,433,784.00
2200	Дотоод эх үүсвэрээр	247,564,192.00	201,433,784.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	247,564,192.00	201,433,784.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(247,564,192.00)</u>	<u>(201,433,784.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>(540,633,854.00)</u>	<u>(8,135,426.00)</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	548,790,800.00	8,156,946.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,156,946.00	21,520.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,076,072,741.26	1,962,233,158.64	11,487,013,463.25	15,525,319,363.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,076,072,741.26	1,962,233,158.64	11,487,013,463.25	15,525,319,363.15
Тайлант үеийн үр дүн			1,974,334,465.46	1,974,334,465.46
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,076,072,741.26	1,962,233,158.64	13,010,229,432.02	17,048,535,331.92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,076,072,741.26	1,962,233,158.64	13,010,229,432.02	17,048,535,331.92
Тайлант үеийн үр дүн	427,155,380.00		-765,024,570.66	-337,869,190.66
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,503,228,121.26	1,962,233,158.64	12,245,204,861.36	16,710,666,141.26

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,320,044,900.00	3,196,069,464.05	123,975,435.95	96.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,320,044,900.00	3,196,069,464.05	123,975,435.95	96.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,258,947,500.00	3,180,024,464.05	78,923,035.95	97.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,030,104,000.00	1,969,455,990.71	60,648,009.29	97.01
210101	Үндсэн цалин	816,886,000.00	756,237,991.00	60,648,009.00	92.58
210102	Нэмэгдэл	337,160,700.00	337,160,700.00		100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,710,200.00	164,710,200.00		100.00
210104	Урамшуулал	148,421,100.00	148,421,100.00		100.00
210105	Гэрээт ажлын хөлс	562,926,000.00	562,925,999.71	00.29	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	243,612,400.00	243,612,400.00		100.00
210201	Тэтгэврийн даатгал	164,626,200.00	164,626,200.00		100.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,746,600.00	19,746,600.00		100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,797,200.00	16,464,616.51	-667,416.51	104.22
210204	Ажилгүйдлийн даатгал	3,949,300.00	3,949,300.00		100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,493,100.00	38,825,683.49	667,416.51	98.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	246,523,300.00	246,114,777.34	408,522.66	99.83
210301	Гэрэл, цахилгаан	58,328,100.00	58,119,532.00	208,568.00	99.64
210302	Түлш, халаалт	155,187,000.00	155,000,000.00	187,000.00	99.88
210303	Цэвэр, бохир ус	33,008,200.00	32,995,245.34	12,954.66	99.96
2104	Хангамж, бараа материалын зардал	174,045,500.00	174,045,500.00		100.00
210401	Бичиг хэрэг	38,150,900.00	37,975,709.00	175,191.00	99.54
210402	Тээвэр, шатахуун	35,654,000.00	44,110,460.51	-8,456,460.51	123.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,616,000.00	22,720,469.49	5,895,530.51	79.40
210404	Ном, хэвлэл	10,805,800.00	10,760,470.00	45,330.00	99.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,280,000.00	12,496,940.00	1,783,060.00	87.51
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,538,800.00	45,981,451.00	557,349.00	98.80
2105	Нормативт зардал	6,268,000.00	6,268,000.00		100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,268,000.00	6,268,000.00		100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	170,714,800.00	170,714,800.00		100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	110,921,400.00	110,873,509.00	47,891.00	99.96
210604	Урсгал засвар	59,793,400.00	59,841,291.00	-47,891.00	100.08

Архивын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	89,207,300.00	78,351,300.00	10,856,000.00	87.83
210701	Гадаад албан томилолт	10,800,000.00	10,556,710.00	243,290.00	97.75
210702	Дотоод албан томилолт	53,397,300.00	42,784,590.00	10,612,710.00	80.13
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	25,010,000.00	25,010,000.00		100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	227,369,000.00	223,141,490.00	4,227,510.00	98.14
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	79,226,500.00	75,607,290.00	3,619,210.00	95.43
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,940,000.00	5,940,000.00		100.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,446,400.00	3,446,400.00		100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,404,500.00	796,200.00	608,300.00	56.69
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	59,123,000.00	59,123,000.00		100.00
210807	Газрын төлбөр	4,968,600.00	4,968,600.00		100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	73,260,000.00	73,260,000.00		100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71103200.00	68320206.00	2,782,994.00	96.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	6,207,610.00	792,390.00	88.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	64,103,200.00	62,112,596.00	1,990,604.00	96.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61097400.00	16045000.00	45,052,400.00	26.26
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,201,700.00	3,045,000.00	1,156,700.00	72.47
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,201,700.00	3,045,000.00	1,156,700.00	72.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,895,700.00	13,000,000.00	43,895,700.00	22.85
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,895,700.00	00.00	43,895,700.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,000,000.00	13,000,000.00		100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	100,000,000.00	89,000,000.00	11,000,000.00	89.00
2200	Дотоод эх үүсвэрээр	100,000,000.00	89,000,000.00	11,000,000.00	89.00
222001	Тоног төхөөрөмж	100,000,000.00	89,000,000.00	11,000,000.00	89.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,320,044,900.00	3,463,003,134.00	142,958,234.00	104.31
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,099,964,900.00	3,099,964,900.00		100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,099,964,900.00	3,099,964,900.00		100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	220,080,000.00	363,038,234.00	142,958,234.00	164.96

Архивын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	220,080,000.00	363,038,234.00	142,958,234.00	-	164.96
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	8,156,946.00			
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	21,520.00			
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ					
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	207.00	207.00			100.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00			100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	95.00	95.00			100.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00			100.00
620004	Гэрээт ажилтан	100.00	100.00			100.00

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Архивын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.02.15			САГ-
Шалгагдсан байгууллагын нэр:	Архивын ерөнхий газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Батлагдсан төсвийн ангилал зориулалтыг зөрчиж дотоод томилолтын зардлаас шатахуун бэлтгэсэн	25,456.4	Зөвлөмж өгсөн	Архивын ерөнхий газрын дарга, Санхүү аж ахуй хэлтсийн дарга	С.Энхбаатар, Б.Цэвэлмаа
2	Архивын ерөнхий газар 2018 жилийн эцсээр өглөг, авлагын үлдэгдэлтэй 2 байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулсан боловч гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны төлбөрийн тооцоог жилийн эцсийн байдлаар тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	246,114.8	Зөвлөмж өгсөн	Архивын ерөнхий газрын дарга, Санхүү аж ахуй хэлтсийн дарга	С.Энхбаатар, Б.Цэвэлмаа
3	Архивын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл, хуулийн хүчин төгөлдөр байдлыг түүвэрлэн шалгахад гарын үсгийн бүрдэл дутуу, гарын үсгийн тайлал байхгүй, эд хариуцагчийн тайланг хянаж, баталгаажуулдаггүй, анхан шатны баримтыг батлагдсан маягтаар хөтөлдөггүй зэрэг зөрчилтэй баримтуудыг нэгтгэн	248,977.8	Залруусан	Архивын ерөнхий газрын дарга, Санхүү аж ахуй хэлтсийн дарга	С.Энхбаатар, Б.Цэвэлмаа

Архивын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	аудитын явцад залруулав.				
4	Төрийн архивын AMS програм хангамжийг хөгжүүлж онлайн ажиллагаатай систем болгон хөгжүүлэхэд системийн шийдэл, шинжилгээ зохиомж боловсруулахтай холбоотой зардлыг системийн өртөгт шингээлгүй тайлант хугацааны зардал болгосон байна	24,637.7	Залруусан	Архивын ерөнхий газрын дарга, Санхүү аж ахуй хэлтсийн дарга	С.Энхбаатар, Б.Цэвэлмаа
	Дүн	545,190.7			

